

**МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ
СҮЛЖЭЭ КОМПАНИ**



ТАНИЛЦУУЛГА

Мэдээлэл холбооны сүлжээ компани нь 21 аймаг 285 сумыг хамарсан 17051 км шилэн кабелийн сүлжээ, хот хоорондын дамжуулах байгууламжийн нэгдсэн сүлжээг эзэмшин, тэдгээрийн байнгын тасралтгүй ажиллагааг хангаж, ашиглалт үйлчилгээг хариуцдаг.

Өнөөдрийн байдлаар манай компани 1500 гаруй инженер техникийн ажилтантай бөгөөд мэдээлэл харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч байгууллагуудад бүх төрлийн үйлчилгээг Монгол улсын өнцөг булан бүрд хүргэх, үйлчилгээ эрхлэх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Бид дараах үндсэн үйлчилгээнүүдийг үзүүлдэг. Үүнд:

- Тоон суваг түрээсийн үйлчилгээ
- Бөөний интернэтийн үйлчилгээ
- Худаг сувагчлалын түрээсийн үйлчилгээ
- Тоног төхөөрөмж, байр, цамхагийн түрээсийн үйлчилгээ
- Техникийн хамтын ажиллагаа
- Дүрст хурлын танхим

ГИШҮҮНЧЛЭЛ

Манай компани Олон улсын цахилгаан холбооны байгууллага /International Telecommunication Union/, Ази номхон далайн бүсийн цахилгаан холбооны байгууллага /Asia Pacific Telecommunity/ -ын гишүүн бөгөөд тус байгууллагуудаас зохион байгуулж буй аливаа үйл ажиллагаанд идэвхтэй оролцож хамтран ажиллаж байна.

Түүнчлэн Азийн бүтээмжийн байгууллага, Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим, Монголын хүний нөөцийн институтын гишүүн байгууллага юм.

Мэндчилгээ



Эрхэм хүндэт харилцагч, үйлчлүүлэгч та бүхний амар амгаланг айлтган танд болон танай байгууллагад амжилт бүтээл, хөгжил дэвшлийг хүсье

Манай компани 2006 оноос Монгол улсын мэдээлэл харилцаа холбооны салбарт үйл ажиллагаагаа явуулж харилцагч, үйлчлүүлэгч байгууллага, аж ахуйн нэгжүүдэд тэдний хэрэгцээ шаардлага, хүсэл зорилгод нийцсэн сүлжээний чанартай, найдвартай, тасралтгүй цогц үйлчилгээгээр хангах үйлсэд хүчин чармайлт гарган ажиллаж ирлээ.

Бид Монгол улсын өргөн уудам нутаг дэвсгэрийг хамарсан мэдээлэл, холбооны үндсэн сүлжээ болох улс, хот хооронд, орон нутгийн дамжуулах байгууламжийн нэгдсэн үйлчилгээг эзэмшиж, тэдгээрийн байнгын тасралтгүй ажиллагаа, ашиглалт үйлчилгээг хариуцан ажилладаг бөгөөд Монгол улсын 21 аймаг 285 суманд 17051км шилэн кабелийн сүлжээг эзэмшиж, түүгээр дамжуулан орчин үеийн олон төрлийн үйлчилгээ үзүүлж байна.

Мэдээлэл харилцаа холбооны салбарын хөгжлийн чиг хандлага, нийт харилцагч, үйлчлүүлэгчдийнхээ хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өгөгдлийн суурь сүлжээндээ өргөтгөл, шинэчлэл хийн шинээр зохион байгуулж өнөөгийн эрэлт хэрэгцээг бүрэн хангахуйц техник технологийн нөхцлийг бүрдүүллээ. Үүний зэрэгцээгээр гадаад хамтын ажиллагаандаа томоохон ахиц гарган гадаад, дотоодын хэрэглэгчдэдээ шинэ төрлийн үйлчилгээг хүргэх суурийг амжилттай тавин ажиллаж байна.

Манай компани үйл ажиллагаандаа ил тод, нээлттэй байдлыг эрхэмлэж, хэрэглэгчдийнхээ итгэлийг хүлээсэн, найдвартай холбооны сүлжээгээр хангах зарчмыг баримтлан ажилладаг бөгөөд цаашид олон улсын стандартыг хангасан шинэ шийдэл, шинэлэг үйлчилгээнүүдийг өргөнөөр нэвтрүүлэх эрхэм зорилготой.

Биднийг үргэлж дэмжин хамтран ажиллаж ирсэн эрхэм харилцагч, үйлчлүүлэгч та бүхэндээ манай компанийн хамт олон талархаж явдгаа илэрхийлэхэд таатай байна.

Та бидний цаашдын хамтын ажиллагаа улам бүр өргөжин тэлнэ гэдэгт гүнээ итгэж байна.

Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай.

Хүндэтгэсэн,

МХС ХХК-ИЙН ШИЛЭН КАБЕЛИЙН СҮЛЖЭЭНИЙ УРТ



ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид өндөр хурдны үндэсний сүлжээгээр орон зай, цаг хугацааны ялгаваргүйгээр цахим үйлчилгээг найдвартай хүргэх нөхцлийг бүрдүүлнэ.

ЗОРИЛТ

Мэдээлэл холбооны сүлжээ компани нь Олон улсын мэдээлэл холбооны зах зээлд Ази-Европыг холбосон транзит урсгалын үйлчилгээг нэвтрүүлж, мэдээлэл холбооны сүлжээний цогц үйлчилгээг үзүүлэгч компани болохын төлөө ажиллаж байна.

ҮНЭТ ЗҮЙЛС

- Үйл ажиллагаагаа ил тод байлгах
- Хэрэглэгчдийнхээ итгэлийг хүлээсэн байх
- Найдвартай сүлжээгээр хангах

ҮНДСЭН СҮЛЖЭЭНИЙ ӨРГӨТГӨЛ ШИНЭЧЛЭЛТ

2015

2014

2013

- 6 Аймаг 8 сум 439км.
- Улаанбаатар-Налайх-Багануур чиглэлд сүлжээний багтаамжийг 10Г болгосон.
- Улаанбаатар-Дашинчилэн хооронд 10Г цагираг сүлжээ байгуулсан.
- Замын үүд-Алтанбулаг чиглэлд үндсэн болон нөөц хоёр чиглэлээр транзит урсгал байгуулсан.

САЛБАР СҮЛЖЭЭ
18 аймаг 130 сум 6900 км

ЦАГИРАГ СҮЛЖЭЭ
25 сум 1803 км

САЛБАР СҮЛЖЭЭ

19 аймаг 150 гаруй сумыг шилэн кабелийн сүлжээнд холбох төслөөр 2010-2014 онд 9000 гаруй км шилэн кабелиар сумдыг холбож холбооны бүхий л төрлийн үйлчилгээг хүргэх боломжтой болсон.

ДОРНОД, СҮХБААТАР, ДУНДГОВЬ ХӨВСГӨЛ АЙМГУУДЫН 30 СУМ 1900 км
ШИЛҮҮСТЭЙ -ГУУЛИН 38 км
БУЛГАН-БҮРЭГХАНГАЙ 32 км
ЛҮН-АЛТАНБУЛАГ 120 км

2012

2009

2007

ЦАГИРАГ СҮЛЖЭЭ

33 сум 1556 км Улаанбаатар
Мөрөн 842 км

ТООН СУВАГ ТҮРЭЭСИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Бид монгол улсын ихэнх сум сууринг хамарсан SDH технологи дээр суурилсан хамгийн том шилэн кабель бүхий хот хоорондын суурь /national back-bone/ сүлжээг эзэмшдэг бөгөөд манай сүлжээ хүрсэн монгол орны аль ч цэгээс нөгөө цэгт хүссэн мэдээллээ дамжуулах боломжийг бүрдүүлэх зорилгоор E1 тоон суваг түрээсийн үйлчилгээ үзүүлдэг.



ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ:

- Ярианы суваг (TDM)
- Өгөгдлийн суваг (Data, MPLS-VPN)
- STM суваг (STM-1, STM-4)

ТЕХНИКИЙН ДАВУУ ТАЛУУД:

Монгол улсын 21 аймаг, 285 сумдад өөрийн шилэн кабелийн сүлжээгээ хүргэсэн өндөр багтаамж бүхий дэд бүтэц

- 7/24 цагийн сүлжээний хяналтын системтэй
- Сүлжээний шинэчлэл сайжруулалт, үзлэг үйлчилгээг байнга хийгддэг.
- Хэрэглэгчийн Ethernet болон шилэн кабелийн холболт
- Олон төрлийн протокол болон холболтыг дэмждэг
- Монгол улсын ихэнх сум суурин газраас сүлжээнд найдвартай холбогдох
- Сүлжээгээ хянах боломжтой
- Цогц тасралтгүй удирдлагын шийдэл




ТРАНЗИТ УРСГАЛ



ТРАНЗИТ УРСГАЛ

Мэдээлэл холбооны сүлжээ компани нь Ази-Европыг холбосон шилэн кабелийн сүлжээгээр мэдээллийн транзит урсгал дамжуулахаар дэлхийн мэдээлэл, холбооны шилдэг компаниуд болох ОХУ, БНХАУ-ын компаниудтай хамтран ажиллаж байна. Манай шилэн кабелийн сүлжээ нь Ази-Европыг холбосон хамгийн дөт зам бөгөөд бид Олон Улсын транзит сувгийн бизнест өөрийн байр суурийг бэхжүүлэхээр ажиллаж байна.



ОЛОН УЛСЫН ТРАНЗИТ СҮЛЖЭЭ


Европ тив буюу Франкфурт, Лондон, Хельсинкийг Ази тивтэй холбосон олон улсын транзит урсгал нь Монгол улс, ОХУ, БНХАУ, Казахстан чиглэлийг дайран Хонг Конг дахь төв нэгдсэн станцад хүрдэг. Ази-Европыг холбосон транзит урсгалаас Монгол улсаар дайрч байгаа кабель нь хамгийн дөт, унтралт саатал буюу delay нь хамгийн бага тул Олон Улсын мэдээлэл холбооны компаниуд Монгол улсыг дайрч өнгөрөх сүлжээгээр мэдээллээ дамжуулах сонирхолтой байдаг.

Жил тутам Ази-Европыг холбосон транзит урсгалын хэмжээ нэмэгдсээр байна

ИНТЕРНЭТИЙН БӨӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ

ИНТЕРНЭТИЙН БӨӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ

Интернэтийн бөөний үйлчилгээ үзүүлэгч (ISP) компаниудад шилэн кабелийн өөрийн сүлжээгээр дамжуулан гадаад гарцаар оруулж ирдэг интернэтийн бөөний үйлчилгээг үзүүлж байна. Интернэтийн бөөний урсгалыг өөрийн шилэн кабелийн сүлжээгээр дамжуулан оруулж ирж байна.



ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДАВУУ ТАЛУУД:

- Улаанбаатар хотын болон 21 аймгийн төв, 285 суманд хүргэх;
- VPN сүлжээ үүсгэх;
- 7/24 цагийн сүлжээний хяналтын систем;
- Гадаад IP хаяг авах;
- Хэрэглэгчдийн мэдээллийн аюулгүй байдал;
- Үйлчилгээний найдвартай байдлыг хангасан, IPсүлжээний нөөц урсгалтай


ХУДАГ СУВАГЧЛАЛЫН ТҮРЭЭСИЙН ҮЙЛЧИЛГЭЭ



Худаг сувагчлалын түрээсийн үйлчилгээ

Улаанбаатар хот болон бүх аймагт ашиглагдах кабель шугамын байгууламжийн ашиглалтын үйл ажиллагааны түвшинг дээшлүүлэх, оновчтой болгох чиглэлээр харилцаа холбооны операторууд, сүлжээ ашиглагч төрийн болон бизнесийн байгууллага, аж ахуйн нэгжид кабелийн худаг, сувагчлал түрээслүүлэх болон техникийн үзүүлэлт хангасан физик кабелийн хос шугам түрээслүүлэх үйлчилгээ үзүүлдэг.

Улаанбаатар хотын хэмжээнд 6005 ширхэг худаг, 487,252.5 метр сувагчлалыг түрээсээр ашиглуулах боломжтой бөгөөд Хотын сүлжээний газраас боловсруулсан техникийн нөхцлийг үндэслэн түрээсийн гэрээ хийж ажиллаж байна.



Тоног төхөөрөмж, байр, цамхагийн түрээсийн үйлчилгээ

Улаанбаатар хот, радио релейний станц, аймгийн төв, дүүрэг, сум суурин газарт байр талбайн түрээсийн үйлчилгээ үзүүлж байна. Өөрийн цамхагт бүх төрөлийн антенн байршуулах боломжтой. Манай үйлчилгээ нь суурин болон үүрэн оператор компаниудад антенн, тоног төхөөрөмжийг өөрийн эзэмшлийн байр, цамхагтаа байршуулж байр талбайн түрээсийн гэрээ хийж харуул хамгаалалтыг бүрэн хариуцаж ажиллаж байна.



ТЕХНИКИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

ТЕХНИКИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Манай компани харилцаа холбооны операторууд, сүлжээ ашиглагч төрийн болон бизнесийн байгууллага, аж ахуйн нэгж нийт 200 гаруй байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Эдгээрээс зарим байгууллагуудын сүлжээ, тоног төхөөрөмжийн техникийн ашиглалт үйлчилгээг (аутсорсингийн) гэрээгээр хариуцан 7/24 байнгын найдвартай ажиллагааг хангаж ажиллаж байна.

Бид мэдээлэл холбооны салбарт үйл ажиллагаа явуулж буй технологийн сүлжээ бүхий холбооны үйлчилгээ эрхлэгчдийн орон нутаг дахь хот хоорондын дамжуулах сүлжээний ашиглалт үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэдэг.

Тухайлбал Мобиком корпорацийн хөдөө орон нутагт орших сайтууд, Нийслэлийн мэдээлэл технологийн газар, замын хөдөлгөөний удирдлагын төв, Нийслэлийн шуурхай удирдлагын төв, болон бусад байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

ХИЙГДДЭГ АЖЛУУД:

- Урьдчилан сэргийлэх үзлэг үйлчилгээг тогтсон график төлөвлөгөөний дагуу хийх (жилд 1-2 удаа)
- Сүлжээний гэмтэл саатлыг захиалгаар засварлах
- Сум орон нутгийн объект, сайтын харуул хамгаалалт
- Зай тэжээлийн бэлэн байдлыг хангах
- Түлш шатахууны нөхөн хангалт хийх
- Хөрөнгийн шилжилт хөдөлгөөн

ТЕХНИКИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА (OUTSOURCING)-ИЙН АЧ ХОЛБОГДОЛ, ҮР ДҮН

- Захиалагчийн ашиглалт үйлчилгээний зардлыг бууруулах
- Зардлаа хянахад хялбар
- Мэдээлэл холбооны үндсэн сүлжээг (Газрын болон Сансарын холбооны) технологийн нэгдсэн удирдлагаар хангаж техникийн ашиглалт үйлчилгээг зохион байгуулдаг арвин баялаг туршлагатай өндөр мэргэшсэн инженерүүдийн хамтын ажиллагаа
- Сүлжээний технологийн үйл ажиллагааг оновчтой болгож бүтээмжийг дээшлүүлэх
- Үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах

СҮЛЖЭЭНИЙ НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГАА

ТОЙРОГ СҮЛЖЭЭ 1

БАЯН-ӨЛГИЙ-УВС -ЗАВХАН-ГОВЬ-АЛТАЙ-ХОВД

ТОЙРОГ СҮЛЖЭЭ 2

ХӨВСГӨЛ-ЗАВХАН-ГОВЬ-АЛТАЙ-БАЯНХОНГОР-ӨВӨРХАНГАЙ-БУЛГАН

ТОЙРОГ СҮЛЖЭЭ 3

ХЭНТИЙ-СҮХБААТАР-ДОРНОГОВЬ-ӨМНӨГОВЬ-ДУНДГОВЬ-ӨВӨРХАНГАЙ-
БУЛГАН-ТӨВ-УЛААНБААТАР-НАЛАЙХ-БАГАНУУР

ТОЙРОГ СҮЛЖЭЭ 4

-ТӨВ-БУЛГАН-ОРХОН-ДАРХАН-УУЛ-ТӨВ-УЛААНБААТАР

ТОЙРОГ СҮЛЖЭЭ 5

ХЭНТИЙ-СҮХБААТАР-ДОРНОД

ХОЛБОО БАРИХ

Төв байр

Чингэлтэй дүүрэг, 1-р хороо Энхтайвны өргөн чөлөө
Улаанбаатар хот 15160, Монгол Улс
Утас: 70112519
Факс: 11-325445
E-mail: info@netcom.mn

Үндсэн сүлжээний газар

Утас: 70112526
Факс: 11-311058
E-mail: long-distance@netcom.mn

Шуурхай удирдлагын төв

Утас: 70112219
Факс: 11-325445
E-mail: dis@netcom.mn

Маркетинг, гэрээ хэлцлийн хэлтэс

Утас: 70112605
Факс: 11-325445
E-mail: marketing@icn.mn

